

БАТЛАВ.
НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГА Р.ЭНХТАЙВАН

2024 оны 4 дугаар сарын 6-ний өдөр

НАЛАЙХ ДҮҮРГИЙН 3 ДУГААР ХОРОО, ИХ УУРХАЙН ОРЧИМ ГАЗРЫН ХЭВЛИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Уул уурхайн ашиглалтын улмаас ухагдаж эвдэгдэн хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж буй газрыг нөхөн сэргээж нийтийн хэрэгцээнд шилжүүлснээр хүн, мал, амьтан гэмтэж бэртэхээс сэргийлэхээс гадна орчны доройтол буурах, иргэд олон нийт эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бололцоо хангагдана.

- Эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд MNS 5915:2008, MNS 5917:2008, MNS 5918:2008 стандартад тодорхойлсон ангилал, чиглэл, БОНХАЖС-ын 2015 оны А-138 дугаар тушаалаар баталсан ангилал зэргийг тус тус баримтална.

Техникийн нөхөн сэргээлт

1. Газрын хэв шинж бүрэн алдагдаагүй алгуур хотойлтыг хэвээр үлдээж болох ба эрэг, ганга үүсгэсэн цөмрөлтүүдийг ил уурхайд тавих шаардлагын дагуу хийж 40 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн байна.
2. Уурхайн олборлолтоос үүссэн элэгдэл, эвдрэлд орсон газрын хоосон оронзай буюу ухашийг хэвгийжүүлэх, овон товон гадаргыг тэгшлэх, нягтруулах зэрэг ажлыг бульдозероор гүйцэтгэх бөгөөд налуу гадаргууг орчных нь гадаргуутай ойртуулан хэлбэршүүлнэ. /хажуу налуу 18°-аас ихгүй байх/
3. Хэлбэршүүлсэн талбайн гадаргуу, ялангуяа налуу хажууг бульдозер болон грейдерийн сийрэгжүүлэгчээр хөндлөн сэндийлж, уг гадаргууг хучсан шимт хөрс аадар борооны уруйн усанд идэгдэхээс хамгаална.
4. Талбайн гадаргыг машин механизм явахад саадгүй байхаар хэлбэршүүлнэ.
5. Далд уурхайн босоо, налуу, хэвтээ малталтуудын амсрыг шаардлагатай тохиолдолд төмөр-бетон хийц ашиглан битүүмжилж гадна талаас нь чулуугаар чигжиж уурхай орчмын газрын гадарга дахь ухсан нүх, ан цавыг дарж бөглөн дүүргэж, хэлбэршүүлэн тэгшилнэ.
6. Талбайд хаягдсан хатуу хог хаягдлыг цэвэрлэнэ.
7. Хуучин уурхайн олборлолтын явцад эмх цэгцгүй далд уурхайн стандартад нийцсэн бэхэлгээ хийгдээгүй, ашигт малтмалын олборлолт явуулснаас үүдсэн нуруулт, цөмрөлт үүсэж болзошгүй тул тухайн орчмын газрыг нөхөн сэргээх, газар ашиглалтын бусад хэлбэрээр ашиглах тохиолдолд эрсдлийг зайлшгүй урьдчилан тооцож мэдээллийг хүргүүлнэ.
8. Техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэх хугацаа 1 сар буюу хуанлийн 30 хоног байна.

Биологийн нөхөн сэргээлт

1. БОНХАЖС-ын 2015 оны А-138 дугаар тушаалаар баталсан аргачлалд зааснаар нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны техникийн үе шат бүрэн дуусаж, талбайн хөрс чулуулаг тогтворжиж, нягтарсны дараа шимт хөрсийг эргүүлэн байршуулах замаар эвдэрсэн газрын биологийн нөхөн сэргээлтийн ажлыг эхлүүлнэ.

2. Их уурхай орчимд ухагдаж эвдэгдсэн талбайг “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” хийх тухай MNS 5917:2008 стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Уурхайн техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд биологийн нөхөн сэргээлт хийхдээ дан шимт хөрсөөр 5-30см зузаантай хучина.
4. Лабораторын шинжилгээгээр баталгаажуулсан шимт хөрсний шинж чанарын үзүүлэлтийг үндэслэн биологийн нөхөн сэргээлтэд 40 га талбайг ургамалжуулах бөгөөд үрийн норм 1 га талбайд 20 кг-аар тооцож, олон настын үрийн соёололт цэвэршилтээр I, II ангид тэнцэх үрээр /ерхөг, согоовор ба түүнтэй дүйцэхүйц/ тарина. Мөн үндсийг бэхжүүлэх зорилгоор 1-ээс 2 настын үрийг тохиромжтой хэмжээгээр тарьж болох бөгөөд биологийн нөхөн сэргээлтийг ургамал ургах боломжтой дулааны улиралд хийж гүйцэтгэнэ.
5. Техникийн нөхөн сэргээлт явуулсан талбайг бульдозероор тэгшилж, хатуурсан талбайг трактороор чирсэн анжисаар борнойдож агротехникийн аргаар хөрсийг боловсруулж, үрлэгч машинаар үрээ жигд суулгана. Үрлэхдээ тууш ба хөндлөн хоёр чиглэлд үрлэнэ.
6. Нийт 40 га талбайгаас 4,0 га талбайд нь тохиромжтой хэмжээгээр тооцон 3-аас доошгүй настай мод тарьна. Тарих модны төрлийг сонгохдоо техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай дахь шимт хөрсний агрохимийн шинжилгээнд үндэслэсэн мэргэжлийн байгууллагын дүгнэлт, зөвлөмжийн дагуу тухайн хөрсөнд таарах, амьдралтын хувь өндөр байхуйц модыг сонгоно.
7. Тарилтын амьдралтын хувь 75%-аас дээш байна.
8. Биологийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэх хугацаа 1 сар буюу хуанлийн 30 хоног байна.

Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийж гүйцэтгэх нийт хугацааг хуанлийн 60 хоног байхаар төлөвлөх бөгөөд үе шатны ажлын хуваарийг мөн 60 хоногоор тооцож ирүүлнэ.

Хавсралт 1-д нөхөн сэргээх газрын сансрын зураг, талбайн солбицолыг тусгав.

Хянасан:
ХБОНБХ-ийн дарга


Ч.Мөнхбаяр

Боловсруулсан:
ХБОБНХ-ийн мэргэжилтэн


Ж.Батзолбоо


ХАВСРАЛТ 1**НӨХӨН СЭРГЭЭХ ГАЗРЫН ТАЛБАЙН СОЛБИЦОЛ**

Талбай. Их уурхайн орчим, Талбай-1,

Талбайн хэмжээ: 35 га

№	Өргөрөг	Уртраг
1	47°45'9.48"N	107°17'46.56"E
2	47°45'9.42"N	107°17'57.66"E
3	47°44'59.88"N	107°17'57.78"E
4	47°44'59.82"N	107°17'49.50"E
5	47°44'54.90"N	107°17'49.44"E
6	47°44'54.66"N	107°17'54.36"E
7	47°44'45.78"N	107°17'54.48"E
8	47°44'45.72"N	107°18'1.20"E
9	47°44'35.88"N	107°18'1.44"E
10	47°44'35.94"N	107°18'9.66"E
11	47°44'28.80"N	107°18'9.42"E
12	47°44'28.80"N	107°18'1.56"E
13	47°44'34.68"N	107°18'1.32"E
14	47°44'34.80"N	107°17'56.28"E
15	47°44'38.70"N	107°17'56.16"E
16	47°44'38.82"N	107°17'46.56"E
17	47°44'47.70"N	107°17'46.26"E
18	47°44'47.82"N	107°17'35.28"E
19	47°45'2.76"N	107°17'35.34"E
20	47°45'2.76"N	107°17'46.56"E

Налайх 3-р хороо
2024 он
Нөвөн саргаэх талбай-1
35 га



Legend

Google Earth
Image © 2024 Airbus

2 дугаар байршил – 3 га

№	Өргөрөг	Уртраг
1	47°45'33.48"N	107°16'59.40"E
2	47°45'33.96"N	107°17'9.48"E
3	47°45'28.74"N	107°17'9.30"E
4	47°45'28.62"N	107°17'1.20"E
5	47°45'30.06"N	107°17'1.38"E
6	47°45'30.00"N	107°16'59.52"E



3 дугаар байршил – 2 га

№	Өргөрөг	Уртраг
1	47°45'24.24"N	107°16'58.44"E
2	47°45'18.78"N	107°16'58.38"E
3	47°45'18.84"N	107°16'49.86"E
4	47°45'21.84"N	107°16'51.96"E

